




ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛ



**ТЕРРОРИЗМЫН ОЛОН УЛСЫН  
НӨХЦӨЛ БАЙДАЛД “КОВИД-19”  
ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ**

---

ТТЗ-ИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
2020-9



## ТЕРРОРИЗМЫН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД “КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Дэлхий нийтийн өмнө КОВИД-19 цар тахал нь шинэ тутам үүсээд буй томоохон бэрхшээлүүдийн нэг болоод байгаа билээ. Аливаа нийгмийн харилцаанд орж буй бүхий л субъектэд хүчтэй нөлөө үзүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааг нь саармагжуулах, цаашлаад тасалдуулахад хүргэж байна. Терроризмын суурь нөхцөл, террорист этгээдүүдэд энэхүү цар тахал нь эерэг болон сөрөг хэлбэрээр нөлөөлж байгаа бөгөөд цаашид ч мөн тодорхой хэмжээнд өөрчлөлт үзүүлэх чиг хандлага ажиглагдаж байгааг олон улсын байгууллагаас онцолж байна. Хөл хорио, улс хооронд зорчих хөдөлгөөний хязгаарлалт зэрэг нь террорист этгээдүүдэд зэвсэглэл олж авах, гадаад, дотоод руу чиглэсэн хөдөлгөөн үйлдэхэд хүндрэл үүсгэж байгаа төдийгүй терроризмын санхүүжилт босгох үйл ажиллагаанд тодорхой саад бэрхшээлийг учруулж байна. Коронавирусын цар тахал болон бусад шалтгааны улмаас үүсээд буй тогтворгүй байдлыг ашиглан террорист этгээдүүд нь өөрсдөдөө давуу тал бий болгож, энэхүү боломжийг ашиглан санаа зорилгоо гүйцэлдүүлж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна.

Цаашид цар тахлыг даван гарсны дараах үед ч террорист этгээдүүд төрөл бүрийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах төлөвтэй байгааг судлаачид анхааруулж байна. Радикалчлах үзэл сурталд автуулах, элсүүлэх, нийгэм рүү чиглэсэн сөрөг үйл ажиллагаа явуулах буюу ард иргэдийг эрх баригчдын эсрэг тэмцэлд уриалах нөхцөл байдал үүсгэхийг үгүйсгэхгүй. Цар тахлын нөлөөгөөс үүдсэн чиг хандлагууд буцаж хэвийн болох бол терроризмд үзүүлэх зарим нөлөө хувьсан өөрчлөгдсөн хэвээр үлдэх төлөвтэй байна. КОВИД-19 цар тахал нь терроризмтой тэмцэх тэмцэлд дараах байдлаар нөлөөлж байна. Үүнд:

### **Оюун санаа, үзэл бодлын дархлаа суларч радикалчлалд өртөх**

Хөл хорио тогтоосон, цаашид хэрхэх нь тодорхой бус байдлаас үүдэлтэй нийгмийн болон хувь хүний стресс зэрэг нь олон нийтийг хамарсан эдийн засгийн болон сэтгэлзүйн хямралд хүргэснээр хорио цээрийн дэглэмийн үеэр цахим орчинд олон цаг зарцуулж буй иргэд радикал үзэлд автах, суртал ухуулгад өртөх таатай нөхцөлийг бүрдүүлж байгааг судлаачид онцолжээ. Энэхүү нөхцөл байдлыг Исламын Улс, Аль-Кайда зэрэг террорист бүлэглэлүүд ашиглахыг эрмэлзэн, өөрсдийн суртал ухуулгыг бусдад түгээх, улмаар иргэдийг элсүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа нь тодорхой үр дүнд хүрээд байна. Тухайлбал, хэт даврагчдын цахим платформ дээрх үйл ажиллагаа эрс нэмэгдэж буй нь нэг тод жишээ бөгөөд хэт даврагчтай холбоотойгоор “Telegram” зэрэг платформ дээр терроризмтой холбоотой шифрлэгдсэн сувгууд ихээр үүсэж, үйл ажиллагаа нь идэвхжих болсныг судлаачид онцлох болсон байна.



Түүнчлэн хэт даврагч зарим бүлэглэлүүд нь КОВИД-19 цар тахлыг зарим шашны номлолд дурдсан хүн төрөлхтний төгсгөл ирнэ гэх зөгнөлтэй холбож Исламын Улс зэрэг томоохон террорист бүлэглэлүүдийн адил хүчирхийллийг өдөөх чиг хандлага руу орж болзошгүй байгааг судалгааны үр дүн харуулах болсон байна.



### **Засгийн газрын эсрэг үзэл суртал нэмэгдэх**

Цар тахлын эсрэг эрх баригчид хангалттай сайн хариу арга хэмжээ авч чадахгүй байгаа нь иргэдийн сэтгэл ханамжийг ихээр бууруулж, засгийн газрын шийдвэртэй холбоотой бухимдал, сөрөг үзэл бодлыг илүү ихээр нэмэгдүүлж, улмаар үзэн ядах хандлагыг бий болгож байна. Уг байдлыг террорист этгээдүүд овжноор ашиглан цар тахлын эсрэг эрх баригчдын зүгээс зохистой арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байгааг олон нийтэд мэдээлэх, түгээх, тэднийг үзэн ядуулах зэрэг олон төрлийн сөрөг мэдээллийг тарааж байна. Тухайлбал, цар тахлын үед үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллагын хүртээмж, хүчин чадал, хүнс болон бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хомсдол, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлууд, эрүүл мэндийн салбарын алба хаагчдын мэргэшсэн байдал зэрэг нь хангалтгүй байгааг олон нийтэд сурталчилж, өөрийн үйл ажиллагаанд дэмжлэг авах хандлага ажиглагдаж байна.

Түүнчлэн төрд дайсагнасан хэт даврагчид, тэдгээрийн хийрхэл, төрийн эсрэг кампанит ажил,





хуйвалдааны онол зэргийг ашиглан олон нийтийн бухимдлаар даамжруулан өөрийн зорилгод хүрэх үзэл баримтлалыг террорист этгээдүүд бий болгохыг эрмэлзэж байна. Энэхүү бухимдлын эсрэг төр засгаас онцгой дэглэмийн бодлого баримтлах, тодорхой үйл ажиллагааг хязгаарлах зэргээр өдөр тутмын амьдралд оролцох байдлаар хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч зарим талаар төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаагийн жишээ бол АНУ-д болж буй арьс өнгөний

үзлийн эсрэг жагсаал цуглаан болон бусад улс орнуудад өрнөж буй эсэргүүцлийн цуглаан бөгөөд энэ нь цаашид өргөжих төлөвтэй байна.

### **Биотерроризмыг үйл ажиллагааны тактикт ашиглах**

Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд цар тахлыг зогсоох чадваргүй байгаа нь эрүүл мэндийн тогтолцооны чадамж болон бусад нөхцөл байдлаас олон нийтэд ил болсон билээ. Өөрсдийн санаа зорилгод хүрэх шинэ арга замыг цаг мөч бүхэнд эрэлхийлж байдаг террорист бүлэглэлүүд энэхүү шинэ боломжийг зүгээр орхихгүй нь тодорхой бөгөөд террористуудын үндсэн арга барил болох хүчирхийлэл, албадлага хэлбэрээр хүний амь нас болон сэтгэл зүйд ноцтой хохирол учруулахад оршдог бол цар тахал нь нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр дагавар, нөлөөллөөр терроризмын санаа зорилгодоо хүрэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд ихээхэн түлхэц болж байна. Өмнө нь амжилтгүй болсон хадлага, дайралт, үйл ажиллагаа, зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэх шинэ боломж нь биотерроризм болж хувирах эрсдэл өндөр юм. Амиа золиослогч этгээдүүд нь биотерроризм үйлдэхэд төгс зохицол бүхий хэрэгсэл болох боломжтой.



Урьд өмнө биотерроризмын томоохон халдлага болсон тохиолдол дэлхий нийтэд бүртгэгдээгүй байгаа хэдий ч тусгай албадын мэдээнд дурдсанаар террористууд SARS-CoV-2 вирусийг ашиглаж халдлага үйлдэхээр төлөвлөж байсныг нотлох баримтаар тогтоосон байдаг. Биотерроризмын халдлага 3 арга замаар үйлдэгдэх боломжтой. Үүнд:

- Энгийн вирус ашиглан олон нийтийг өвчлүүлэх буюу ахуйн хүрээний өвчлөлийг нэмэгдүүлэх;
- Вирусийг ашиглан тодорхой үзэл суртлын зорилтот бүлгүүдэд тараах буюу дунд түвшний халдлага үйлдэх (жишээлбэл тодорхой хүн амын бүлгүүдэд зориудаар тараах);
- Цар тахлын мөчлөг буюу үргэлжилж буй хугацааг уртасгах зорилгоор дэгдэлтийн давлагааг санаатайгаар дахин зохион байгуулж өөрт давуу байдал бий болгох, вакцин гаргах үе шатуудад саад учруулах үйл ажиллагаа явуулах.

### **Цар тахлын үеийн уламжлалт халдлага**

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотой олон нийтийн зүгээс үзүүлж болзошгүй эрсдэл болон эмх замбараагүй явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор улс орнууд цэргийн хүч болон бусад тусгай албадыг бэлэн байдлын зэрэгт ажиллуулах, хүн ам олноор цугларахыг хязгаарлах зэрэг арга хэмжээ авсны үр дүнд террорист этгээдүүдийн зүгээс ирэх халдлага дайралтууд эрс багассан. Гэвч нууц далд аргаар өөрийн сүлжээг өргөтгөх, хүн элсүүлэх, сургах, кибер халдлага үйлдэх, суртал ухуулга түгээх, цар тахлын тархалттай холбогдуулан хүмүүнлэгийн хандив тусламж цуглуулах, санхүүжилт босгох зэрэг үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулсаар байна.



### **Тусгай албадын анхаарал суларч, тэмцэх чадавхад нөлөөлөх хүчин зүйлс**

Терроризмтой тэмцэх албад, тэдгээрийн алба хаагчид нь энгийн иргэдийн адил вирусийн халдвар авах эрсдэлтэй бөгөөд үүний улмаас терроризмтой тэмцэх үйл явц тасалдах, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид сэтгэл санааны хямралд автах нөхцөл бүрдэх нь терроризмтой тэмцэх тэмцэл саармагжих эрсдэл болж байна. Террорист бүлэглэлүүд терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн алба хаагчдын анхаарал суларсан,

дархлаа эмзэг болсныг далимдуулан халдлага үйлдэхийг өөрийн салбар бүлгүүд болон элсэн орсон дэмжигч нарт уриалсаар байна. Цар тахлын улмаас улс орнууд дотооддоо чиглэсэн үйл ажиллагаанд анхаарах болсноор терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын бэхжээд байсан харилцаа, холбоо, мэдээлэл солилцох тогтолцоо суларч байгаа нь олон улсын түвшинд тулгарч буй бэрхшээл болж байна. Терроризмтой тэмцэх үйл ажиллагаа нь ирэх жилүүдэд цар тахлаас хамаарч хязгаарлагдах төлөвтэй байгаа бөгөөд тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд боловсон хүчний хомсдолд орох болон мэргэшсэн байдал алдагдахад хүргэх зэрэг сөрөг үр дагаврууд илрэн гарах болно.

### **ДҮГНЭЛТ**

Терроризмын нөхцөл байдалд цар тахал эерэг болон сөрөг нөлөөг үзүүлж байна. Террорист байгууллага, этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаа нь удааширч, санхүүжилт олж авах, зэвсэглэлээр хөөцөлдөх, уламжлалт аргаар шинэ гишүүд, дагагчид элсүүлэх ажил саармагжиж байна. Түүнчлэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд цар тахалтай холбоотой үйл явдлын мэдээ, мэдээлэл бэлтгэхэд түлхүү анхаарч байгаа бөгөөд терроризмоос нийтлэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Цар тахлын үеэр террорист этгээдийн зүгээс олон нийтийг тодорхой үзэл сурталд автуулах, худал мэдээлэл тараах, радикалчлал, экстремизмд уруу татах, засаг захиргааны нэгжийн эсрэг аливаа тэмцэлд өдөөн турхирах зэргээр сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Терроризмд өртөж болох объектын хувьд эрүүл мэндийн байгууллага болон бусад хараа хяналт суларсан стратегийн ач холбогдолтой объектууд руу хялбар аргаар их хэмжээний хохирол учруулах боломжийг нэмэгдүүлж байна. Терроризмтой тэмцэж буй алба хаагч нь дан ганц терроризм бус цар тахлын аюул заналд өртөх эрсдэлтэй байгаагаас терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагын хамтын ажиллагаа суларч улмаар боловсон хүчний хомсдолд орох, мэргэшсэн байдал алдагдах томоохон эрсдэлтэй тулж байгаа нь цар тахлын нөлөө юм.

Иймд цар тахалтай холбоотойгоор олон улсад үүсээд буй терроризмын шинэ чиг хандлагууд манай улсад ч нөлөөлөхийг үгүйсгэхгүй. Иргэдийн цахим орчинд өнгөрүүлэх хугацаа нэмэгдэж төр засгийн удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэрийг эсэргүүцэх зэргээр сөрөг нөлөөлөл нийгэмд бий болгож байна. Энэхүү үйл явц нь олон улсын жишигт терроризм, террорист үйлдэл гарах суурь нөхцөлийг бүрдүүлэх анхдагч хүчин зүйл болж байгаа тул түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарал хандуулан ажиллах шаардлагатай юм.

#### **Эх сурвалж:**

1. НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн (2020). "Impact of Covid-19 on violent extremism and terrorism" танилцуулга